

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-12

1. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 5-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Х.Ганхуяг;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Ч.Лодойсамбуу, А.Ундраа, О.Цогтгэрэл.

Нэг. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, Б.Пүрэвдорж, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 10 дахь дэд заалтын “үе шаттайгаар” гэснийг “зэрэг эхлүүлэхийг эрмэлзэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирон хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа, тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох” гэсэн 11 дэх дэд заалтыг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулах ажлыг анхаарах” гэсэн 12 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 15
Бүгд: 17
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад “Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх үе шатад Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн 13 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад “төмөр замын ачаа тээвэрт 2 тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх” гэсэн 14 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн өгөөж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 57 минутад хэлэлцэж дуусав

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон "Их эзэн Чингис хаан" танхим
13 цаг 25 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд, Энхбаярын Батшугар, Ганзоригийн Лувсанжамц, Бадрахын Найдалаа, Отгоншарын Батнайрамдал, Жамбалын Ганбаатар, Мэндбаярын Мандхай, Пүрэвжавын Сайнзориг, Саруулсайханы Цэнгүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл, Батбаярын Жаргалан, Баатаржавын Мөнхсоёл, Лхасүрэнгийн Соронзонболд, Мөнхчулууны Энхцэцэг, Ринчинбямбын Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирц 60 хувьтай байна. Хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирлээ. Ингээд ирц 60 хувьтай байна. 2024 оны 12 сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудал дээр, эцсийн хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг шигтгэсэн төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан болно. Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн үед

хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар чиглэл өгсөн саналын томъёоллуудаар санал хураалт явуулах болно.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ц.Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Жавхланбаатар тус яамны ТНБД, Намчинсүрэн тус яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Ганбаатар тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Хулан тус яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Зам, тээврийн хөгжлийн яам Дэлгэрсайхан Зам, тээврийн хөгжлийн сайд, Артур тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Итгэлт тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга. Гадаад харилцааны яамнаас алга байна. Эрдэнэс Тавантолгой компани Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Цэрэндондог Эрдэнэс Тавантолгой компанийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналын томъёоллыг тогтоолын төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг та бүхэнд тараасан. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Сайнзориг гишүүнээр нэр тасалъя. Ирцэд яахгүй, таны юуг шууд хэлнэ. Батсүмбэрэл гишүүн асуулт.

Н.Батсүмбэрэл: Дахиад хэлье. Энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа. Энэ олон жил гацчихсан, хүлээгдчихсэн, ялангуяа энэ эдийн засгийн том төслүүд явж байгаатай холбоотойгоор энэ бүтээн байгуулалтын ажлыг түргэсгэх, шуурхай ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа. Их Хурлын гишүүд ч энэ дээр нэлээн бүтээлч хандаж, саналуудаа гаргаж байгаа. Энэ дээр чухам энэ чинь эцсийн хэлэлцүүлэг явж байгаа учраас би 2 сайдын үгийг сонсмоор байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Зам, тээврийн сайд 2 энэ хэлэлцээрийнхээ үйл явдлыг, үр дүнг хэрхэн дүгнэж байна вэ? Үр дүн ямар байдлаар гарна гэж үзэж байна вэ? Энийгээ нэг дүгнэж хэлээч гэж асууя.

Дараагийнх нь энэ редакцтай холбоотойгоор энэ хамгийн сүүлд энэ Мягмарцэрэн хариулах юм болов уу, хэн хариулах юм бол энийг? Тогтоолын төслийн хэрэгжилтэд хяналт тавь гэдэг дээрээ Аюулгүй байдлын байнгын хороон дээр Эдийн засгийн байнгын хороогоо нэмчихсэн. Тэгээд заавал энийг дарж, дахиж бичих шаардлага байсан уу? Тийм дэгтэй юм уу? Энэ 2 сайдын үгийг сонсьё.

Р.Сэддорж: 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ бол анх яригдаж эхэлсэн он бол 2003 он, 2009 онд 2 улсын Засгийн газар хоорондын комиссын шийдвэрээр энэ төмөр замыг барих энэ асуудал бол яригдсан. Сүүлд нь 2014 онд 2 улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ерөнхийлөгч Ши Жиньпиний айлчлалын үеэр ингээд шийдэгдсэн ийм асуудал. Тэгээд шийдлээ хүлээж янз бүрийн гацаанд орж явсаар байгаад өнөөдрийг хүрсэн. Тэгээд бид энэ асуудлаа гаргалгааг нь гаргаж шийдвэрлэж явахгүй бол манай уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх ийм боломжгүй болчихоод байгаа юм. Ер нь бол хамгийн дээд хүчин чадалдаа 80 сая тонндоо тулчихсан байгаа.

Тэгэхээр энэ төмөр замын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтыг холбож байж Гашуунсухайтын боомтоор бол 30-аас доошгүй сая тонн нүүрсний экспорт нэмэгдэх, мөн энэ боомтыг холбосны дараагаар үе шаттайгаар дараагийн буюу Ханги, Мандал, Шивээхүрэн, Сэхээ, Бичигт, Зүүнхатавчийн боомтуудын төмөр замын хил холболтууд хийгдсэнээр тухайн боомт болгоноор 10 сая тонноос доошгүй нүүрсийг экспортод гаргах ийм нөхцөл бүрдэх юм. Тэгэхээр энэ хэлэлцээрийг хийхийн тулд нэлээн удсан, маргаантай байсан ийм хэлэлцээр учраас Улсын Их Хурлын тогтоолоор 2 улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр байгуулах үндсэн чиглэлээ аваад, энэ чиглэлийнхээ хүрээнд Улсын Их Хурал тогтоолоо баталсны дараагаар шууд 2 улсын Засгийн газрын хоорондоо хэлэлцээрийнхээ төслийг батлах ажил руу орно.

Тэгээд энийг бол 2 талт хэлэлцээр учраас цаг хугацаа ялангуяа нөгөө урд хөршийн талаас ямар цаг орохыг бид шууд хэлж чадахгүй байна. Тэгэхдээ бид бол бид урьдчилсан байдлаар маш яаралтай горимоор манайд саналаа энэ хэлэлцээр байгуулах явцаа хийнэ гэдэг байдлаар ярьсан байгаа. Тэгээд хэлэлцээрийг баталсны дараагаар дахин Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар орж ирнэ. Соёрхон батлагдсаны дараа 2 ААН-үүдийн хоорондын гуравласан гэрээ явна гэдгийг хэлье.

Хэлэлцээний шатад хийгдэх энэ асуудал дээр 2 төрлийн үр дүн, үр ашиг гарч ирнэ гэж ингэж харж байгаа. Тэр нь юу гэхээр шууд энэ нүүрсийг бол бид ямар нэгэн бартер оффтейкээр биш борлуулж байгаа учраас эндээс мэдээж энэ борлуулалтын валютын эх үүсвэр нэмэгдээд явна. Бусад дам буюу давхар ашгууд энэ дээр маш олон гарч ирнэ. Юу гэхээр бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгаж өгсөн, Улсын Их Хурал баталж өгсөн энэ төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхүүр нөхцөл нь яг энэ хамгийн гарааны нөхцөл нь энэ Гашуунсухайт-Ганцмод төмөр замын хил холболт байгаа юм. Тэгээд энийг шийдэгдсэнээр 2 улсын хоорондын маш олон бүтээн байгуулалт, хамтын ажиллагааны түгжээ мултарч, асуудлууд гацаанаасаа гарч явах ийм нөхцөл бүрдэж байгаа. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя Туваан сайд.

Ц.Туваан: Энэ хил холболтын төмөр замаас цаашлаад төмөр замын 3 боомтын хил холболт бол яг холбох байдал, байгалийн төвөгшил энэ тэр нь бол гайгүй, 2 талаасаа төмөр замууд нь ирчихсэн байгаа ийм холболтууд байгаа. Тэгээд мөн энэ тогтоолын 11 дүгээр зүйл заалтад гаргаж оруулсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит маш олон чиглэлийн компаниудтай харилцан хамтран ажиллах, хөрөнгө оруулалт хийх нөхцөлүүд бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Р.Сэддорж: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд би нэмж дээр нь төмөр замтай холбоотой юмыг л ганц нэг үг, үсгийн зөрөөтэй юмыг энэ ингээд бид энэ хэлэлцээрийг хийхдээ хэдий Хятадын захидал гэж манай гишүүд хараад байгаа боловч бид бол үндсэндээ 60 удаа уулзаж, энэ дээр ойлголцсон юм. Тэгэхээр зэрэг манай гишүүд ингээд утга агуулгын хувьд зарим нэг зүйл алдагдчих вий гэдэг дээр маш болгоомжилж байгаа. Яагаад вэ гэхээр урд

хөрш бол ингээд үг, үсэг дээр ноцолдоод, ингээд янз бүрийн юм болдог учраас энийг зөв ойлгоорой гэдэг талаас нь хэлье.

Тэгээд энэ дээр нэг манай тогтоолын төсөл дээр орж ирсэн нэг ийм энэ 5 дугаар зүйл дээр та хэд маань нэг анхаарч өгөөч. Зүгээр энэ одоогийн хуучин бид нарын орж ирсэн томьёоллоор нь хийж өгч туслаач. Тэгэхгүй бол ингээд Эрдэнэс Тавантолгойн уул уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сурталчлахгүй байх гээд ингээд тодотгоод өгчихсэн энэ сүүлийн томьёолол дээр энэ нь бол манай Эрдэнэс Тавантолгой яг Чайна Энержитэй хийх гэрээндээ энийгээ бол тодорхой тусгаж өгөх юм. Тэгэхээр зэрэг энэ 2 улсын Засгийн газрын хооронд хийгдэж байгаа гэрээ дээр ийм бүүр ийм компани хоорондын ярьж байгаа юмыг оруулмааргүй байна гэдгийг 1 дүгээрт анхаарч өгөөч гэдгийг хэлмээр байгаа юм.

2 дугаарт бусад асуудал дээр сая зарим гишүүд маань саналаа татаад, ингээд зарим санал дэмжигдээгүй учраас энэ томьёоллоороо явах юм байна гэж ойлгож байгаа.

10 дугаар бүлэг дээр би энэ Жаргалан гишүүний томьёоллыг хэлсэн үгийг бол нэг талаар зөв гэж үзээд, тэгээд энэ томьёолол дээр энэ Жаргалан гишүүнтэй санал солилцоод, тэгээд энэ Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээрээ Монгол Хятадын хилийн Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Зүүнхатавч зэрэг боомтуудын төмөр замаар холбох ажлыг аль болох зэрэг эхлүүлэхийг эрмэлзэх гэж ийм томьёоллоор оруулж өгвөл болох юм байна гэж бид 2 ингээд ярьж, үг, үсгийн хувьд ингээд зассан юм. Энийг дэмжиж өгөөч гэж. Тэгээд бусад нь бол яг энэ хуучин томьёоллоороо байхад бол болж байгаа юм. Энэ тэр юун дээр дараагийн дугаарт энэ юунаас ажлын хэсгээс нөгөө шинэ томьёолол гаргаж өгсөн. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Дэлгэрсайхан сайд гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Засгийн газраас энэ Хуулийн хэлтэс үзээд, дахиад өчигдөр орой бид суугаад нэг үг, үсэг өөрчилье гэдгийг энэ Батнайрамдал гишүүн унших юм байгаа юм. Энэ Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг 11-д оруулаад, энэ төмөр замтай хольж болохгүй учраас машин, авто замын боомт гэдгийг нь 11 дээр оруулаад, тэгээд 12-т нь энэ одоогийн байгаа 11-ээ 12-тоо авч үлдье гэдэг ийм саналтай байгаа юм. Энийг маань дэмжиж өгөөч гэдгийг хэлж байгаа юм. Баярлалаа та бүхэнд.

Р.Сэддорж: Энхтүвшин гишүүнийг нэмье. 2 гишүүний дараа Пүрэвдорж гишүүн асуулт асууна. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би нөгөө гүйцээн боловсруулах өгсөн 2 саналын 1 маань агуулгын хүрээнд Сэддорж гишүүний хураалгасан саналтай давхцах гэж байна гэж үзээд хураалгах шаардлагагүй болов уу гэж би бодоод байгаа юм. Зүгээр орон нутагт ажлын байр бий болгох гэдгээсээ хэдүүлээ харин Сэддорж дарга зөвшөөрч байвал зүгээр орон нутагт гэдгээ 2/3-оор хасчихмаар байна. Ер нь зүгээр ингээд шинээр ажлын байр бий болгох. Зөвхөн орон нутаг гээд яг тодотгох хэрэг байна уу?

Ер нь зүгээр яах вэ Монголын дотоодын аж ахуйн нэгж, байгууллагыг энэ бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагаа дээр туслан гүйцэтгэгчээр оролцуулах гэдэг санааг бүгд тал талдаа хэлээд байгаа гэж би ойлгож байгаа. Тээвэрлэлт дээр ч гэсэн. Тэгэхээр яах вэ үүнтэй давхцаж байвал би энэ саналаа хураалгах шаардлагагүй гэж үзэж байна.

2 дахь дээр бол сая Дэлгэрсайхан сайд чуулган дээр хэлсэн учраас би ярихгүй л гэж бодогдож байгаа юм. Гэхдээ манай Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурал дээр оруулж байгаа санал, дүгнэлт дээр яг гишүүдийн юу хэлж байгаа тодорхой оруулмаар байна. Санал хэлж, үг хэллээ л гээд байгаа болохоос юу хэлсэн нь мэдэгдэхгүй ингээд өнгөрчхөөд байх юм. Тэгэхээр би бол Монгол Улсын Засгийн газрын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг Монголын эрх ашигт нийцүүлж, Монгол Улсаас гарч байгаа бараа, бүтээгдэхүүн буюу Хятадыг чиглэн гарч байгаа нийт экспортын бүтээгдэхүүний 1/3-тэй тэнцэх хэмжээний бараа, бүтээгдэхүүнийг Хятадын нутаг дэвсгэрээр тодорхой хэмжээний хөнгөлөлттэйгөөр гуравдагч орны боомт дээр хүргэх энэ асуудлыг цаашдаа ярих ёстой юм. Ярьж байж дотоодын экспортоо нэмэгдүүлэхээс гадна, энэ экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлмээр байна. Энийг битгий орхигдуулаарай гэдэг зүйлийг протоколын хувьд үлдээгээд явчихъя.

Тэгээд ер нь бол Дэлгэрсайхан сайд хэлж байна шүү дээ орхихгүй гэсэн. Тийм учраас энийг дахиж хураалгахгүйгээр үлдээе. Протоколын хувьд Дэлгэрсайхан сайд энэ дээр анхаарна гэдэг зүйлээ Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр хариултаа өгчих нь зөв байх гэж бодож байна.

Р.Сайнзориг: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Би Сайнзориг гишүүний хэлж байгаатай санал нэг байгаа. Мэдээж бид энэ гуравдагч орны улсаас манай улс маш их хэмжээний бараа таваар импортоор авдаг. Тэгээд бид гуравдагч орон руу экспорт хийдэг ийм асуудлууд гардаг учраас цаашдаа бол энэ Хятадын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрч байгаа ачаа тээврийн хөнгөлөлтийн нөгөө Орост авдаг хөнгөлөлттэй адилхан энэ хөнгөлөлтийн асуудлаар бид тусдаа, жичдээ урд хөрштэй ярина гэдгийг илэрхийлье энэ ташрамд. Баярлалаа.

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүнийг нэмье. Энхтүвшин гишүүн. Найруулгын асуудал.

Д.Энхтүвшин: 2 дээрх найруулгыг засахдаа, гүйцээн боловсруулах чиглэлээр зассан юм шиг байна. Тэгээд төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр ашгийг гээд. Энэ өөрөөр хэлбэл яг энэ 5 дээрхтэй адилхан, тэгээд 5 дээр яг төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн өгөөж гэсэн яг энэтэй адилхан болгож өөрчилъе. Тэгэхгүй бол нөгөө агуулга нь өөр болчхож, хүчин чадлын эдийн засгийн үр өгөөж гээд явчихна. Тийм биш, зам, төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр ашгийг гэдэг байдлаар явах нь зөв юм байна. Яах вэ зүгээр нөгөө нэг хоёулаа өмнө ярихад 2 хүчин зүйл байгаа. Нүүрс худалдаж, худалдан авах гэрээнд чинь 1 дүгээрт нь хүчин чадалтай холбоотой. Өөрөөр хэлбэл энэ барьсан төмөр замаар чинь оффтейк урт хугацааны хэмжээ явна гэсэн баталгаа 1 дүгээрт чухал.

2 дугаарт энэ хөрөнгө оруулалт чинь эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байх гэдэг 2 ийм шалтгааны үндсэн дээр нүүрс худалдаж, худалдан авах гэрээг хийж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хоёрыгоо тодотгох үүднээс л оруулаад байгаа юм. Тэгэхээр тээврийн хүчин чадал, нөгөөдөх нь эдийн засгийн гол нь үр ашиг, үр өгөөж хоёрыг нэг болгоё гэсэн чинь энэ дээр 2 өөр утгатай явах нь л дээ. Тэгэхээр энэний зүгээр энэ доогуур зураастай тэмдэглэчихсэн байгаа биз. Төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн гэж явчихвал ард нь 5 дугаар зүйлийг та хар даа. 5 дээр болохоор яг төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөж гэдэг яг энэтэй л адилхан болгочихъё гэсэн ийм санал.

Р.Сэддорж: Баярлалаа. Энхтүвшин гишүүн одоо таны юун дээр санал хураалт дээр яг түүн дээрээ ярьчихъя. Тэгэхээр ажлын хэсгийнхэн ажиллаж байгаа биз дээ наанаа үг, үсэг дээрээ. Сайд нь энд ингээд байх юм. Тэгээд тэр цаана нь бичиг цаасан дээр ажиллаж байгаа биз дээ. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Их Хурлын даргаас миний гаргасан 11 дүгээр санал дээр чиглэл өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл дэмжсэн. Тэгэхээр энд ажлын хэсгийн 2 хариуцаж байгаа 2 сайд нь бол, Ерөнхий сайд, Их Хурлын дарга дэмжээд явж байгаа. Энэ баруун бүсэд маш хэрэгтэй заалт байгаа. Тэгэхээр Сэддорж дарга энэ Сэддорж дарга таны гаргасан нөгөө заалтуудыг өөрчлөх санал чинь сая Их Хурал дээр дэмжигдчихсэн шүү дээ. Тэгэхээр миний, Жаргалан гишүүний гаргасан тэр зэрэг гэдэг заалт бол төмөр замын холболтын асуудал дээр яригдсан асуудал. Энэ бол 11 дүгээр заалтаар бол цэвэр авто замын холболтын асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр энэ нөгөө та нар ингээд төмөр замын холболт яриад байна гэж ярьж байгаа. Энэ чинь энэ төмөр замын холболтоор чинь гол нь нүүрсээ экспортлох тухай л асуудал ярьж байгаа. Тийм учраас энэ миний гаргасан энэ 11 дүгээр заалт бол цэвэр баруун бүсийн нүүрсийг экспортлох тухай асуудал юм байгаа юм. Тийм учраас энэ 11-ийг ямарваа нэгэн байдлаар эвдэхгүйгээр хэвээр нь санал хураалгаж өгөөрэй гэж би танаас хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Ажлын хэсгийнхэн суугаарай. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Би зүгээр нэг зүйлийг асуунгаа сануулж хэлье л гэж бодож байна л даа. Ил тод байдлын талаар. Энэ стратегийн орд газруудын талаарх гэрээ хэлэлцээрийг төрийн өмчит компани төр оролцоод хийхдээ ил тод байдлыг хангах, ил тод байлгах гэдэг энэ өгүүлбэрийг оруулах хэрэгтэй юм болов уу? Оюу толгойн гэрээ дээр ийм өгүүлбэр байдаг шүү дээ. Тэгэхээр энэ төртэй байгуулж байгаа аливаа гэрээ хэлэлцээрт нээлттэй, ил тод байх ёстой энэ заалтыг оруулж өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Р.Сэддорж: Туваан сайд. Орж байгаа юу гэж?

Ц.Туваан: Энийг Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулчхаж болно таны саналаар. Тийм, Засгийн газрын хоорондын хэлэлцээрт оруулчхаж болно.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарим зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн эдгээр саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 10 дахь дэд заалт заалтын “үе шаттайгаар” гэснийг “зэрэг эхлүүлэхийг эрмэлзэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Саяын томьёоллоор санал хураалт. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. Батсүмбэрэл гишүүн суугаарай.

Тогтоолын төслийн, 2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр” гэж нэмэх. Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал. Энэ дээр ярьсан уу ажлын хэсэгтэйгээ? Ажлын хэсэг энэ дээр ямар юутай байгаа юм бэ? Батнайрамдал гишүүний ярьсан уу? Туваан сайд.

Ц.Туваан: Батнайрамдал гишүүнийхээр байж болно гэж үзэж байгаа.

Р.Сэддорж: Ингээд санал хураалт саяын томьёоллоор. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирон хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа, тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох” гэсэн агуулгатай 11 дэх дэд заалтыг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдэж байна. Батболд, Мандхай гишүүн нарыг дэмжсэнээр санал тэмдэглэе.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтад Монгол Улсын, тогтоолын төслийн 1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хоорондын Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулах ажлыг анхаарах” гэсэн агуулгатай 12 дахь заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Энийг ярьсан уу хоорондоо, ярьчихсан уу? Тэгээд энийг яаж байгаа юм уу? Санал хураалт. 11,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх үе шатад Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн агуулгатай 13 дахь заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Энэ ажлын байршил нь орон нутаг л юм чинь тэгээд тэнд чинь Монгол Улсын бүх иргэд ажиллаж байгаа 9 аймаг. Татчих юм уу? Зүгээр яах юм байна. Санал татах гэсэн ойлголт байхгүй юм байна, хураагаад л яачихъя. 5,9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын 6.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “төмөр замын ачаа тээвэрт 2 тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх” гэсэн агуулгатай 14 дэх дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан. Алдаржавхлан гишүүн байна уу? Энийг ажлын хэсэг ярьсан уу? Төмөр замын ачаа тээвэрт 2 тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх гэсэн 14 дэх дэд заалт нэмэх гэж байна. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Тэрийг түрүүн чуулган дээр хэлсэн. Хэлэлцээр дээр нь оруулья 2 төмөр замын. Тэгээд энэ том гэрээнээсээ хасья гэдэг ийм саналтай байсан. Энийг манай гишүүд дэмжихгүй байж өгөөч.

Р.Сэддорж: Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. 7.Тогтоолын төсөл дэх нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн өгөөж” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Туваан сайд.

Ц.Туваан: Энхтүвшин гишүүний саналаар сая бас чуулган дээр хэлсэн энийг нэг болгоё гээд. Тэгээд үр өгөөжөөр гээд аваад явчхаж болно.

Р.Сэддорж: Саяын томъёоллоор санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ Монгол хэлний үг үсгээрээ маш сайн мэтгэлцэж байгаад гишүүдэд талархаж байна. Тэгээд энэ бол бид Монголоороо энэ гэрээнийхээ төсөл дээр үг, хэллэгээ маш сайн сайжруулах хэрэгтэй. Тогтоолын төслийн талаар зарчмын, санал хураалт дууссан, дууссан шүү дээ. Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах танилцуулгыг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батболд танилцуулна.

13.57 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

